

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТАЛААРХ БОДЛОГЫН СУДАЛГАА

Ө. Мөнхсайхан

*Төрийн захиргааны менежментийн магистр
Бизнесийн ахисан түвшний сургууль
Шинжлэх ухаан технологийн их сургууль
Munkhsaikhan_u@yahoo.com*

Я. Төгөлдөр

*Доктор (Ph. D.), дэд профессор
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
Шинжлэх ухаан технологийн их сургууль
tugul@must.edu.mn*

Хураангуй: Монгол улс төрөөс нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай иргэдийн амьдралын наад захын хэрэгцээг нь хангах, нийгмийн баталгааг нь алдагдуулахгүй байх зорилгоор 1995 онд нийгмийн халамжийн анхны бие даасан хуулийг баталсан. Нийгмийн халамжийн багц хуульд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан ба өнөөдрийн байдлаар 6 хуулийн хүрээнд 72 төрлийн халамжийн хөтөлбөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Нийгмийн халамжийн бодлого хөтөлбөрүүд нь хүн амын ядуурлыг бууруулах, амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэх, хүндрэл бэрхшээл тулгарсан иргэдийн эмзэг байдлыг сааруулахад туслах зорилготой хэрэгждэг. Өнөөгийн нийгмийн халамжийн хөтөлбөрүүд үр дүнгүй, хавтгайрсан байх магадлалтай гэж таамаглал дэвшүүлэн хэр үр дүнтэй, оновчтой хөтөлбөрүүд хэрэгждэг эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор тоон статистикийн аргыг ашиглаж баримт бичгийн шинжилгээ хийсэн юм. Судалгааны хүрээнд үр дүнтэй хөтөлбөрт агуулагдах долоон шинж чанараар хөтөлбөрүүдэд анализ хийж халамжийн хөтөлбөрүүдийг эрэмбэлсэн бөгөөд тэдгээрийн зорилго, чиглэл, ижил төстэй шинж, давхцал зэргийг харгалзан халамжийн хөтөлбөр, алдар гавьяаг урамшуулах хөтөлбөр, хүн амын өсөлтийг дэмжих хөтөлбөр гэж 3 ангилан авч үзсэн. Түүнийхээ хүрээнд 2019 онд хэрэгжсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн тоон статистик мэдээлэлд тулгуурлан халамж хавтгайрсан эсэхэд дүн шинжилгээ хийхэд таамаглал батлагдаагүй үр дүн гарсан.

Түлхүүр үгс: Халамжийн хөтөлбөр, үр дүнтэй бодлого, нийгмийн халамж, үйлчилгээ

I. УДИРТГАЛ

Нийгмийн халамжийн тогтолцоо хэр сайн ажиллаж байгааг дүгнэхийн тулд бодлогын зорилго хангагдаж байна уу, нийгмийн халамж юунд зарцуулагдаж байгааг, ядуу эмзэг иргэн, гэр бүлд зарцуулагдаж байна уу, үүнээс тэд хангалттай үйлчилгээг авч чадаж байна уу гэдгийг авч үзэх хэрэгтэй.

Монгол улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүд бодлогын зорилгыг хангахуйц оновчтой эсэхэд дүн шинжилгээ хийснээрээ тулгамдаж буй

асуудлыг авч үзэх, бодлого боловсруулагчдын анхаарлыг энэ асуудалд хандуулах ач холбогдолтой юм.

Нийгмийн халамж нь хүн амын хамгийн эмзэг ядуу хэсгийн амьжиргаанд дэмжлэг үзүүлж, ядуурлыг бууруулах, түүнчлэн бусдын туслалцаагүйгээр бие даан амьдрах чадваргүй ахмад настан, өнчин хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг төрөөс зайлшгүй харж хандах шаардлагатай хүн амын тусгай хэрэгцээт эмзэг хэсгийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор тухайн цаг үеийн бодлогын хүрээнд хэрэгжиж, өнөөгийн болон ирээдүйд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нийгмийн халамжийн хөтөлбөрүүд, нийгмийн даатгал, ядуурлыг бууруулах болон бусад нийгмийн бодлогуудтай нягт уялдаатай хэрэгждэг.

Манай улсын хувьд нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн зорилго нь ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллыг сайжруулахаар хэрэгждэг ч тэтгэмжийн хэмжээ, халамж хүртэж буй зорилтот бүлэг, тэтгэмжид хамрагдах шалгуур үзүүлэлт зэргийг аваад үзвэл түр зууртаа эмзэг байдлыг нь намжаах, аргацаах, тухайн үеийн нөхцөл байдалд нь дэмжлэг үзүүлэх зорилготой хөтөлбөрүүд дийлэнх нь байна. Эдгээр хөтөлбөрүүдийн зорилтот бүлгийг хэрхэн сонгож буйг харахад нэг хөтөлбөрөөс бусад бүх мөнгөн тэтгэмжийн болон нөхөн олговорын хөтөлбөрүүд нь хүн амын бүлгээр буюу категорын аргаар зорилтот бүлгээ тодорхойлсон байна. Харин ядуу иргэдэд тухайлан чиглэсэн (өөрөөр хэлбэл ядуу иргэдийг зорилтот бүлгээ болгосон) ганц хөтөлбөр бол хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ бөгөөд хөтөлбөрөөс үр шим хүртэх зорилтот бүлгээ Орлогыг орлуулан тооцох арга (ООГА) ашиглан тодорхойлж 2019 оны жилийн эцсийн байдлаар 265.511 иргэн хөтөлбөрийн үр шимийг хүртсэн байна. [1]. Монгол улсын нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд болон үйлчилгээ нь олон нийт, судлаачдын шүүмжлэлтэй ханддаг сэдвүүдийн нэг бөгөөд улсын эдийн засаг, хөгжлийн чухал үзүүлэлтийн үндсэн хэсэг байдаг.

II. ОНОЛ АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Нийгмийн халамжийн бодлогын үзэл баримтлалын талаар хэдэхэдэн онол хандлагыг авч үзлээ. “Нийгмийн халамж” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсвэл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа гэж тодорхойлсон байдаг [2].

“Нийгмийн халамж” гэж иргэдийн ашиг тусын төлөө төрөөс явуулдаг нийгмийн төрөл бүрийн үйлчилгээнүүд юм [3]. Азийн хөгжлийн банкны тодорхойлсноор нийгмийн халамжийн тусламж гэдэг нь нийгмийн хамгийн эмзэг бүлгийн өрх, олон нийтэд тэдний наад захын хэрэгцээг хангах, амьдралын чанарыг сайжруулахын тулд боловсруулсан хөтөлбөрийг хэлнэ (Howell 2001). Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагын тодорхойлсноор нийгмийн халамжийн тусламж гэдэг нь орлогын доод түвшинд байгаа өрхийг дэмжих, хүнд хэцүү нөхцөлд амьдарч байгаа хүмүүст туслах, нийгмийн гадуурхалтыг бууруулах, өөрөө өөрийгөө авч явах чадавхийг нэмэгдүүлэхийн тулд үзүүлж байгаа тусламжийг хэлнэ (Adema 2006)

Дээрх тодорхойлолт, үзэл баримтлалуудаас “Нийгмийн халамж”-ийг нийгэмд байгаа хүндрэл бэрхшээлтэй нүүр тулан тэмцэж буй иргэдийн амьдралд дэмжлэг үзүүлэх, амьдрах итгэл, найдварыг бий болгох үйл ажиллагаа гэж ойлгож болохоор байна. Энэхүү ойлголтод үндэслэн халамжийн бодлогууд зөвхөн эмзэг бүлэгт чиглэж тэднийг сайн сайхан амьдруулах хэрэгцээг хангахаар төлөвлөгдөх нь чухал юм. Иймд энэ хүрээнд нийгмийн халамжийн бодлого, хөтөлбөрийг шинжилж болохоор байгаа бөгөөд судалгааны ажлынхаа үндэслэл болгож байгаа юм.

Улс орнуудад нийгмийн халамжийн бодлого яагаад хэрэгтэй вэ? Аливаа улс оронд төрөөс зайлшгүй дэмжин туслах шаардлагатай эмзэг, ядуу хэсэг байдаг. Эдгээр өрх иргэдэд улс бүр төр, нийгмийн тогтолцоо, хүн ам, ядуурлын түвшин, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн нөхцөл байдал болон бусад хүчин зүйлсээс хамааран өөрийн онцлогт тохирсон нийгмийн халамж, хамгааллын тогтолцоог бий болгон хэрэгжүүлдэг.

Нийгмийн халамж нь ядуурлыг бууруулах, эрсдэлийн менежментийг сайжруулахад дараах дөрвөн чиглэлээр нөлөөлдөг байна. [4]

1. Нийгмийн халамж, тэтгэмж нь тэгш бус байдал болон туйлын ядуурлыг бууруулахад шууд нөлөө үзүүлдэг
2. Нийгмийн халамж нь өрх гэр бүлд ирээдүйдээ хөрөнгө оруулах боломж олгодог
3. Нийгмийн халамж нь өрх гэр бүлд эрсдэлийг зохицуулахад тусалдаг
4. Нийгмийн халамж нь Засгийн газарт үр ашигтай шинэчлэл хийх боломж олгодог байна.

Монгол улсын нийгмийн халамжийн бодлого нь тэгш бус байдал болон туйлын ядуурлыг бууруулах, өрх гэр бүлд эрсдэлийг зохицуулахад голчлон чиглэдэг.

Нийгмийн халамжийн бодлого олон улсад. Европын холбооны шинэ гишүүн орон Болгар улсын нийгмийн халамжийн бодлого: Болгар улс нь нийгмийн хамгааллын системтэй нягт уялдаатай нийгмийн халамжийн цогц тогтолцооны үлгэр жишээ орон болж байна. Болгар улс өмнө

нь социалист орон байсан ба дахин хуваарилалтын хүчтэй бодлогуудыг хэрэгжүүлж байсны үр дүнд тэгш бус байдал харьцангуй бага байдаг. Нийгмийн халамжийн тогтолцоо нь гурван үндсэн хөтөлбөрөөс бүрддэг байна. Үүнд: (1) нийгмийн даатгалын хөтөлбөр, үүнд тэжээгчээ алдсаны тэтгэмж, өвчний улмаас чөлөө авах болон хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж мөн жирэмсэн эхчүүдэд олгох тэтгэмж гэх мэт (2) идэвхгүй ба идэвхтэй хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүд, (3) нийгмийн халамжийн тогтолцооны хөтөлбөрүүд багтана. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь ДНБ-ий нилээдгүй их хэсгийг дахин хуваарилдаг ба хүн амын багагүй хэсгийг хамардаг. Нийгмийн халамжийн тогтолцооны төв нь бага орлоготой болон эмзэг өрх бүлд зориулсан таван хөтөлбөрөөс тогтоно. Гол хөтөлбөр нь орлогын баталгаажсан доод түвшний хөтөлбөр бөгөөд энэ хөтөлбөрт тодорхой орлогын босгоос доогуур орлоготой өрхүүд хамрагддаг байна. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн гол үүрэг нь нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдэд хамрагдаагүй ядуу иргэдийг хамрах, тэдэнд хөдөлмөрийн зах зээлд орох боломж олгох эсвэл суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэгддэг байна.[5]

Зүүн Азийн хөгжингүй орны улсуудын нийгмийн хамгааллын бодлого:

Япон улс нь ДНБ-ий 23 хувийг нийгмийн хамгаалалд зориулдаг ба үг үзүүлэлтээр зүүн Азийн бүс нутгийн тэргүүлэгч орон боловч эдийн засгийн нөөцийн дөрөвний нэгээс илүү хувийг зарцуулдаг Нордикийн орнуудын хойно байна. Японы халамжийн тогтолцооны онцлог өвөрмөц байдал нь “Продактивист” буюу консерватив Бисмаркийн загвараар загварчлагдсан нийгмийн аюулгүй байдлыг хангасан систем бөгөөд хувийн халамжийн үйлчилгээ ба нийгмийн халамжийн өргөтгөсөн загвар юм. Япон улс нь төрөөс зарцуулах төсвийг нарийн тусгаагүй хэдий ч одоогийн халамжийн бодлого нь нилээд боловсронгуй төрийн нийгмийн хамгааллын бодлогод үндэсний хөгжлийн асуудал, боловсрол, эрүүл мэндийн асуудал нэн тэргүүнд тавигдсан байдаг. Халамжийн гол 3 хууль нь дэлхийн 2-р дайнаас хойш хэрэгжиж эхэлсэн. Цаашлаад эдгээр хууль нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ажилгүйчүүдийн даатгал болон үйлдвэрийн ослыг багтаасан. Нийтийн тусламжийн хууль (1950), Хүүхдийн халамжийн хууль (1949), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн бодлого (1949) эдгээр нь засгийн газрын чухал ач холбогдолтой [6]. Скандинавын орнуудын парагоны шилдэг төлөөлөл Швед улсын нийгмийн хамгааллын бодлого:

Швед болон бусад Нордикийн орнууд хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлоготой хослуулан орлогын аюулгүй байдлыг хангаж, дахин хуваарилдаг уламжлалтай. Энэ нь универсализмын үнэт зүйл гэж үзэж болно. Түүнчлэн бүх иргэдэд үзүүлэх халамжийн хөтөлбөрүүд, хөгжлийн

бэрхшээлтэй иргэдэд өдөр тутмын амьдралдаа гэр бүл, хандив тусламжаас хамааралгүй бие даасан байх боломжийг олгох нийгмийн үйлчилгээ нь ажлын байраар хангах замаар иргэдийн оролцоог дэмжих арга хэмжээ багтана (Esping-Andersen, 1990; Huber & Stephens, 2001; Hvinden, 2004; Kautto, 2010; Kvist, Fritzell, Hvinden, & Kangas, 2012). Швед улс нь универсалист бодлогыг 1930-аад оноос эхлэн хэрэгжүүлсэн. Дэлхийн II дайны дараагаас бүх нийтийн орлоготой холбоотой нийгмийн хамгааллын халамжууд, хөдөлмөрийн зах зээлийн үндэсний бодлого, эрүүл мэндийн болон хувийн нийгмийн үйлчилгээний өргөжилтийг бий болгосон. Ийм хөгжил нь "хүчирхэг нийгэм" гэсэн үзэл сурталтай нягт холбоотой байсан бөгөөд үүнд улс төрд нийгмийн инженерчлэл, нийтийн ашиг тустай үйлчилгээ, хүртээмжийг сайжруулсан нийгмийн халамжийг хөгжүүлж, иргэдийн янз бүрийн хэрэгцээг хангахад үндэслэсэн байв. 10 гаруй төрлийн үйлчилгээг хууль ёсны дагуу зөвшөөрч, нийгэмд хэрэгжүүлэх болсон. Тухайлбал, хувийн асаргаа, компанийн үйлчилгээ, 12-оос доош насны хүүхдийг сургуульд хамруулах, хүүхдүүд, насан хүрэгчдэд зориулсан асаргаа үйлчилгээ, зөвлөгөө болон бусад дэмжлэгүүд багтана. Хувийн асаргаа шаардлагатай хүмүүс асрамжлагчаа өөрөө сонгодог болсноос гадна өөрийн гэр бүлийн хүнээр үү, агентлагаар уу, эсвэл ТББайгууллагаар уу зэргийг өөрөө сонгодог байна. [7]

Монгол улсын нийгмийн халамжийн бодлого. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед Нийгэм хангамжийн социалист тогтолцоо, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тогтолцооны эрх зүйн орчин бүрдэж нэгдмэл агуулгатай байв. Эдийн засгийн шинэ харилцаанд шилжсэний дараа 1995 онд нийгмийн халамжийн анхны бие даасан хууль болон Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай, Тахир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийг УИХ-аас батлан нийгмийн халамжийн бие даасан тогтолцоо бүрдэх эрх зүйн орчин бүрдсэн. Үүнээс хойш нийгмийн халамжийн хуулийг 1998, 2005, 2012 онд шинэчлэн найруулж, 1997, 2000, 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Эдгээр шинэчилсэн найруулга нэмэлт өөрчлөлтөөр нийгмийн халамжийн тогтолцооны ерөнхий үзэл баримтлал нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн хэвээр байсан бөгөөд гагцхүү халамжид хамруулах шалгуур, нөхцөл зэргийг өөрчилж ирсэн байна. Монгол улсад 2004 онд нийгмийн халамжийн чиглэлээр 3 хууль хэрэгжиж байсан бол өнөөдрийн байдлаар Нийгмийн халамжийн тухай хууль (2012), Ахмад настны тухай хууль (2017), хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016), Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай (2011), Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль (2017), Алдар цолтой ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль (2017) зэрэг 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. [8]

Эдгээр нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн зорилго нь хүн амыг нийгэм эдийн засгийн эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгахад чиглэсэн байдаг бол зарим нь халамжийн хөтөлбөрийн үндсэн агуулгыг хангахгүй буюу алдаршуулах, гавьяаг үнэлэх хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Манай улсад хэрэгжиж буй нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг авч үзье. 13 төрлийн нийгмийн халамжийн хөтөлбөрөөр дамжуулан 72 төрлийн үйлчилгээ хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр үйлчилгээ мөнгөн тэтгэмж болон үйлчилгээ гэсэн 2 хэлбэрээр иргэдэд хүрдэг байна. Үүнийг илүү ойлгомжтой авч үзвэл:

Хүснэгт 1. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн ангилал

Хөтөлбөрийн төрөл	Мөнгөн хөтөлбөр	Үйлчилгээ
Нийгмийн халамжийн тэтгэвэр	+	
Нийгмийн халамжийн Асаргааны тэтгэмж	+	
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	+	
Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	+	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж хөнгөлөлт	+	
Алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлт	+	
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		+
Хүнс тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээ		+
“Эхийн алдар” одонтой эхийн тэтгэмж,	+	
Насны хишиг	+	
Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж	+	
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	+	
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	+	
	11	2

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээрх хүснэгтээс үзэхэд Монгол улсад хэрэгжиж буй нийт хөтөлбөрүүдийн 84,6% нь мөнгөн хэлбэрээр тусламж дэмжлэг олгох замаар хэрэгждэг бол үйлчилгээ хэлбэрээр хэрэгжиж буй хоёрхон хөтөлбөр байгаа юм. Энэ нь халамжийн хөтөлбөрүүдээр дамжин их хэмжээний бэлэн мөнгөний урсгал явагдаж байдаг нь харагдаж байна.

Бусад Монгол шиг дундаж орлоготой улс орнууд харилцан адилгүй боловч томоохон хэмжээний ач холбогдол бүхий нийгмийн халамжийн тогтолцоотой байдаг. Нийгмийн халамжийн бүрэн хамралттай тогтолцоо нь урт хугацааны

ядууралд өртсөн иргэд, хямралд өртсөн иргэд болон эмзэг бүлэгт багтах бүлгүүдэд чиглэсэн байдаг. Цөөн тооны хөгжиж буй улс орнууд дээрх гурван бүлгийг гурвууланг нь бүрэн хамарч чаддаг ба ихэвчлэн урт хугацааны архаг ядууралд өртсөн иргэдэд зориулсан мөнгөн хөтөлбөрүүд хамгийн сайн боловсруулагдсан байдаг байна. Ихэнх орнууд урт хугацаанд ядуу байгаа иргэдийн хэрэгцээг хангах зорилготой зорилтот бүлгүүдэд чиглэсэн мөнгөн тэтгэмжийн тогтолцоог бий болгосон байдаг бөгөөд энэ нь өөр өөр шалтгаанаас үүдэлтэй. Тухайлбал, Европ болон дундад Азийн орнууд өмнөх эдийн засгийн нөхцөлтэй уялдаагүй тогтолцоог өөрчлөх зорилгоор, Латин Америк болон Карибийн тэнгисийн орнуудад бол нийгмийн халамжийн хэт нүсэр тогтолцоог хязгаарлах зорилгоор, харин зарим орнуудад их хэмжээгээр нийтлэг олгогддог барааны хөнгөлөлтийг өөрчлөхийн тулд хэрэгжүүлдэг. [9]

Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцооны шинж чанар. Нийгмийн халамжийн тогтолцоо нь онолын хувьд төрийн болон нийгмийн бодлоготой харилцан холбоотой, өөр хоорондоо нягт уялдаатай хөтөлбөрүүдээс бүрддэг ба дараах шинж чанарыг агуулсан байдаг байна. [10] Үүнд:

1. Нийцтэй байх – Хөтөлбөрүүд нь өөр хоорондоо болон төрийн бодлогын бусад элементүүдтэй нийцсэн байх ёстой.

2. Хүртээмжтэй байх – нийгмийн халамж нь тусламж шаардлагатай зорилтот бүлгийг бүгдийг нь хамарсан байх шаардлагатай

3. Үр ашигтай байх – Зардлын хувьд үр ашигтай хөтөлбөр нь санхүүжилтийн ихэнхийг өөрийн зорилтот бүлэгтээ хүргэж чаддаг

4. Тэгш шударга хуваарилах – Халамж түүний үр шимийг хүртэж байгаа хүмүүст ижил тэгш, шударга байдлаар хуваарилах

5. Бэлэнчлэх сэтгэлгээ бий болгохгүй байх – нийгмийн халамж нь сайн ба муу ямар нэг байдлаар хүмүүсийн зан үйлд нөлөөлж байдаг. Энэ өөрчлөлтийг эерэг байлгахын тулд нийгмийн халамж нь өрх гэрийн наад захын хэрэгцээг хангах, өрхийн гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэхэд туслах ёстой

6. Тогтвортой үргэлжлэх боломжтой байх – Хөтөлбөр нь улс төрийн болон санхүүгийн хувьд тогтвортой байх шаардлагатай бөгөөд энэ нь хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг бий болгоно.

7. Динамик – нийгмийн халамжийн тогтолцоо нь байнга өөрчдөгдөн хөгжиж байдаг. Хөтөлбөрүүдийн хоорондын харьцаа нь эдийн засгийн өөрчлөлт, өсөлт болон хөгжлийн бодлогод гарсан дэвшил, эсвэл хямралт нөхцөл байдал зэргээс хамааран өөрчлөгдөж байдаг.

Монголын нийгмийн халамжийн бодлого хэрхэн зөв, үр дүнтэй хөтөлбөрүүдээр дамжин хэрэгжиж буйг дээрх онолын хүрээнд шинжилж үзье.

Монгол улсад хэрэгжиж буй халамжийн хөтөлбөрүүд үр дүнтэй байна үү?

Зорилтот бүлгийн иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа нийгмийн халамжийн 13 багц хөтөлбөрт дээрх 7 шинж чанарыг хэрхэн агуулсан эсэхэд тоон матрицийн аргыг ашиглан (1-сул нөлөөтэй, 2- дундаж

нөлөөтэй, 3-их нөлөөтэй) шинжилгээ хийлээ. Шинжилгээ хийхдээ Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институтаас гаргасан 2015-2019 оны салбарын статистик мэдээлэлд үндэслэн тоон статистикийн арга ашиглаж хөтөлбөрийг хүн ам хүртсэн байдал, зорилтот бүлгийг сонгох шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн дизайн зэргийг харгалзаж зөвхөн судлаачийн зүгээс анхдагч үнэлгээг хийсэн болно. Цаашид нийгмийн халамжийн хөтөлбөрт оролцогчид болон хэрэглэгчдээс судалгааг гүнзгийрүүлэн авч үр дүнг харьцуулж болох юм.

Хүснэгт 2. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн үр дүнгийн шинж чанарыг харуулсан нөлөөлөл

Шинж Чанар	Нийцтэй байх	Хүртээмжтэй байх	Үр ашигтай байх	Тэгш шударга хуваарилалт	Бэлэнчлэх сэтгэлгээ бий болгохгүй байх	Тогтвортой үргэлжлэх	Динамик	Нийт
Хөтөлбөр								
Нийгмийн халамжийн тэтгэвэр	2	3	3	3	2	3	2	18
Нийгмийн халамжийн Асаргааны тэтгэмж	2	2	3	2	2	2	2	15
Онцгой тохиолдлын болон АДМТ	1	2	3	3	2	3	2	16
Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	1	1	2	2	2	2	2	12
ХБИ-нд үзүүлэх тусламж хөнгөлөлт	1	1	2	2	2	2	2	12
Алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлт	1	1	2	1	2	2	2	11
ОНОТХҮ	2	2	2	3	2	2	2	15
ХЭБҮ	2	3	3	3	1	2	2	16
“Эхийн алдар” одонтой эхийн тэтгэмж	2	1	2	2	3	2	2	14
Насны хишиг	1	1	2	2	3	2	2	13
Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж	2	2	1	1	2	2	2	12
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	2	3	2	3	1	2	2	15
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	2	3	1	3	2	1	2	14

Нийт	19	24	27	30	25	27	26
------	----	----	----	----	----	----	----

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

(Зорилтот бүлгийн иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж буй халамжийн хөтөлбөрүүдийг шийдвэрийн оновчтой байдлыг гаргадаг матрицын арга ашиглан үнэлсэн)

Үр дүнтэй хөтөлбөрийн 7 шинж чанарыг хэрхэн агуулж байгааг нөлөөллөөр харахад хамгийн өндөр үр дүн агуулсан хөтөлбөр нь нийгмийн халамжийн тэтгэвэр, үүний дараа онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ байгаа бол эдгээр 7 шинж чанарыг хамгийн бага агуулсан хөтөлбөр нь алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлт байна.

Мөн нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжиж буй дээрх 13 хөтөлбөрүүдэд тэгш шударга хуваарилалт хамгийн өндөр нөлөөлөлтэй, харин бусад бодлого хөтөлбөрүүдтэй нийцтэй байх шинж хамгийн бага нөлөөтэй харагдаж байгаа юм.

Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд зорилтот бүлэгтээ хүрч чадаж байна уу? Дээрх нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжиж буй 13 хөтөлбөрийг мөн зорилго, агуулга, шинж чанар, үйлчилгээ хүртэгч зорилтот бүлгээр авч үзвэл 3 нь буюу 23% нь дан ахмад настанд чиглэсэн, 3 нь буюу мөн 23% нь хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн, үлдсэн 7 нь буюу 54% нь халамж тусламж үзүүлэхэд чиглэсэн гэж хэлж болохоор байна.

Халамж хүртэж буй зорилтот бүлгүүд:

Ахмад настнууд: Тэтгэвэрийн насны хүмүүсийн 70 орчим хувь нь дор хаяж нэг халамжийн хөтөлбөрт хамрагдаж байна. Ахмад настны хамрагддаг тусламж хөнгөлөлтийн 76 орчим хувь нь хэд хэдэн төрлийн хөтөлбөр буюу насны хишиг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж, алдар цолтой ахмад настанд үзүүлэх нэмэгдэл хөнгөлөлтөөс зэрэг үр шим хүртдэг хүмүүст очиж байна. Энэ нь ахмад настны хэрэгцээг хангах зорилготой хөтөлбөрүүдийн тархай саланги шинж байдлын тодорхой илрэл байж болох юм. Иймд ахмад настанд зориулсан илүү цогц хөтөлбөр бий болгоно гэвэл тэдэнд үзүүлэх тусламж болон нийгмийн халамжийн шилжүүлгийн аль алины элементийг агуулсан байх хэрэгтэйг илтгэж байна. [11] Гэхдээ алдар цол, гавьяанд үндэслэсэн хөтөлбөр буюу алдар цолтой ахмад настанд үзүүлэх нэмэгдэл хөнгөлөлтийн үйлчилгээг аажмаар зогсоох асуудлыг ХНХЯам 2020 оны 11 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж алдар цолтнууд харьяа яамнаасаа тэтгэмж авдаг тогтолцоонд шилжиж буй явдал нь сайшаалтай юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд: Өрхийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 66%, 16-аас доош настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 87% нь дор хаяж нийгмийн халамжийн нэг хөтөлбөрт хамрагддаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд очиж буй халамжийн 43% нь зөвхөн нэг хөтөлбөр (гол төлөв нийгмийн халамжийн

тэтгэвэр)-өөс үр шим хүртэгчдэд очдог бол хэд хэдэн хөтөлбөрөөс үр шим хүртэгчдийн хувьд нийгмийн халамжийн тэтгэмж шилжүүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж хөнгөлөлт эзэлж байна. [12]

Ядуучууд: Өрхийн мэдээллийн нэгдсэн сан дахь 5 бүлгийн хамгийн бага оноотой (харьцангуй бага хэрэглээтэй) бүлэгт багтаж буй өрхийн нийт иргэдийн 62% нь дор хаяж нэг нийгмийн халамжийн хөтөлбөрийн шууд үр шим хүртэгч байна. Гэхдээ Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг хасч тооцвол энэ тоо 29% болж буурна. [13].

Хүснэгт 3. Зарим төрлийн нийгмийн халамжийн хөтөлбөрүүд өрхийн амьжиргааны 5 түвшинд хуваарилагдсан байдал

Үзүүлэлт	Хэмжих нэгж (Хувиар)	1-р түвшин (Харьцангуй бага хэрэглээтэй)	2-р түвшин (Доод хэрэглээтэй)	3-р түвшин (дундаж)	4-р түвшин (дундажаас дээгүүр)	5-р түвшин (илүү Улүү өндөр хэрэглээтэй)
ХЭБҮ	Нийт зардлын хувь	100%				
	Хуваарилагдсан хувь	40%				
Алдар цолтой ахмад настанд олгох тэтгэмж	Нийт зардлын хувь	35%			65%	
	Хуваарилагдсан хувь	80%			20%	
НХТэтгэвэр тэтгэмж	Нийт зардлын хувь	50%-иас дээш		50%		
	Хуваарилагдсан хувь	40%		60%		
Эх хүүхдийн мөнгөн тэтгэмж	Нийт зардлын хувь	50%		50%		
	Хуваарилагдсан хувь	40%		60%		
Ахмад настанд олгох тэтгэмж	Нийт зардлын хувь	20%		80%		
	Хуваарилагдсан хувь	11%		89%		

Эх сурвалж: Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт” төсөл, “Монголын ардын ухаан арга, билгийн төв” ТББ, “Нийгмийн халамжийн салбарын ажилтнуудыг чадавхжуулах моуль сургалтын гарын авлага 1-ын мэдээлэлд үндэслэн судлаачийн боловсруулснаар

Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрүүдийн зардал ООТАргачлалаар тодорхойлсон хүн амын амьжиргааны түвшний 5 бүлэгт хэрхэн хуваарилагдсанаас харахад дундаж хэрэглээтэй өрхөөс дээш буюу дээгүүр хэрэглээтэй болон илүү өндөр хэрэглээтэй өрхийн гишүүд нийгмийн халамжийн үр шимийг хүртэж байгаа байдал харагдаж байна. Гэтэл нийгмийн халамж нь шууд утгаараа харьцангуй бага хэрэглээтэй болон доод хэрэглээтэй өрхийн ихэнх массыг хамарч байх ёстой юм. Хамгийн зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөр бол ХЭБ-ийн хөтөлбөр бөгөөд зардал нь 100% хамгийн доод амьжиргаатай 40%-д хуваарилагдсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ хавтгайрсан уу?

Монгол улсын Засгийн газар 2019 онд оны үнээр тооцсон ДНБ 37,3 их наяд төгрөг байгаагийн 1,8% нь нийгмийн халамжийн зардал, МУ-ын нэгдсэн төсвийн зарлага 11,4 их наяд төгрөг байгаагийн 5,9% нь нийгмийн халамжийн зардал эзэлж байсан. [14]

ОУХБ, ҮСХ хамтран гаргасан “Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, улс орны төлөв байдал” тайлангын үр дүнгээр Монгол улсын хүн амын 56,0% нь наад зах нь нийгмийн хамгааллын нэг үйлчилгээнд хамрагдсан байна. [15]

Монгол улсад нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг авч үзвэл 1. Дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай өрх, иргэдэд олгож буй тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээнүүдийг халамжийн хөтөлбөрт, 2. Хүн амын өсөлтийг буюу хүүхэд төрүүлэх боломжийг нэмэгдүүлсэн, эхийг алдаршуулсан, хүүхдүүдэд ялгаваргүй олгогдож буй тэтгэмжүүдийг хүн амын өсөлтийг дэмжих хөтөлбөрт, 3. Хүн амын бүлгийн алдар цол хүртсэнд урамшуулал олгож буй хөтөлбөрийг алдар гавьяаг урамшуулах хөтөлбөрт тус тус ангилан үзэж болохоор байна.



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээрх ангилалын хүрээнд манай улсын 2019 онд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан иргэдийг статистик мэдээллийг нэгтгэн авч үзье.

Хүснэгт 4: Монгол улсын 2019 онд нийгмийн халамжид зарцуулсан төсөв, хамрагдсан хүний тоо

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 он
Нийгмийн халамжийн тэтгэвэр	Хүний тоо	62640
	Мөнгөн дүн	111569,5
Нийгмийн халамжийн Асаргааны тэтгэмж	Хүний тоо	65109
	Мөнгөн дүн	47677,9
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	Хүний тоо	53986
	Мөнгөн дүн	30246,0
Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	Хүний тоо	294110
	Мөнгөн дүн	30206,2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж хөнгөлөлт	Хүний тоо	63133
	Мөнгөн дүн	11496,1
Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл хөнгөлөлт	Хүний тоо	4417
	Мөнгөн дүн	5163,9
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	Хүний тоо	15294
	Мөнгөн дүн	1696,6
Хүнс тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	Хүний тоо	264511
	Мөнгөн дүн	35810,0
Насны хишиг	Хүний тоо	138383
	Мөнгөн дүн	21754,2
Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж	Хүний тоо	294087
	Мөнгөн дүн	115468,3
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	Хүний тоо	81625
	Мөнгөн дүн	13315,5
Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тэтгэмж	Хүний тоо	223250
	Мөнгөн дүн	29291,2
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	Хүний тоо	1000557
	Мөнгөн дүн	229592,0


Эх сурвалж: Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын статистик-2019

Статистик мэдээллээс харахад Монгол улсын нийт хүн амын 80,1% нь буюу 2,561102 иргэн (хүүхдийн мөнгөн тэтгэмжийг оруулаад) 2019 онд нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагджээ.

Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдсан 2.561102 иргэнийг халамжийн хөтөлбөр болон хүн амын өсөлтийг дэмжих хөтөлбөр, алдар гавьяаг урамшуулах хөтөлбөрийн хувьд зааглаж үзвэл 49,1% нь буюу 1.255670 нь өсөлтийг дэмжих хөтөлбөрт, 50,7% нь буюу 1.301015 иргэн халамжийн хөтөлбөрт, 0,2% буюу 4417 иргэн алдар гавьяаг урамшуулах хөтөлбөрөөс тус тус үр шим хүртсэн байна.

Үүнийг график ашиглан харвал нийгмийн халамжийн гэх тодотголтой нийт хөтөлбөрийн тал хувь нь эмзэг ядуу иргэдэд дэмжлэг тусламж үзүүлэх,

тэдэнд тулгамдсан асуудлыг нь бууруулах зорилгоор бус харин хүн амын өсөлт, төрөлт, зарим нэг алдар гавьяаг урамшуулах зорилгоор үр шимээ хүртээсэн байна гэж харж болохоор байна.



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

IV. ДҮГНЭЛТ

Монгол улсын Засгийн газраас ядуурлыг бууруулах зорилгоор олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ч эдгээр хөтөлбөрүүд ядуу болон эмзэг бүлгийн зорилтот хүмүүст онцгойлон хүрэхгүй, харин нийгмийн тодорхой бүлгүүдэд буюу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн эхчүүд, тэжээгчээ алдсан хүүхдүүд, өрх толгойлсон эцэг эхчүүд, олон хүүхэдтэй эхчүүд, төрийн хүндэтгэл хүлээсэн хүмүүст хүрч байна. Мөн чанартаа хүний эрхийн наад захын хэрэгцээгээ хангах чадваргүй, эрүүл мэндийн доройтолтой, хэн нэгний халамж асрамж шаардлагатай, бие даан амьдрах чадваргүй, зайлшгүй дэмжлэг тусламж шаардлагатай өрх иргэнд нийгмийн халамж хүрэх ёстой.

Нийгмийн ядуу болон эмзэг бүлэгт хөрөнгө, нөөцийг чиглүүлснээр өгөгдсөн төсвийн хүрээнд хүрэх үр дүнг дээшлүүлэх, эсвэл зорьсон үр дүнд бага зардлаар хүрэх боломжийг нэмэгдүүлнэ. Хөрөнгө нөөцийг тодорхой бүлэгт чиглүүлэх нь онолын хувьд маш их үр дүнтэй. Жишээлбэл, халамжийн тэтгэмжийг хүн амын ихэнх хэсэгт тараахын оронд зорилтот бүлгийн иргэдийг оновчтой тодорхойлж хүн амын хамгийн ядуу 20%-д чиглүүлж чадвал төсөв тэр хэмжээгээр хэмнэгдэх, эсвэл ядуу хэсэгт өгөгдсөн төсвийг хангалттай зарцуулах боломж бүрдэнэ. Түүнчлэн хамгийн үр дүнтэй хөтөлбөрүүдэд илүү хөрөнгө зарцуулах, үр дүн, үр нөлөө багатай хөтөлбөрүүдийг нэгтгэх, аамжаар зогсоох нь халамжийн бодлого оновчтой болох алхам болно. Түүнчлэн хүн амын зарим бүлгийн алдар гавьяаг урамшуулах, үнэлэх зорилготой хөтөлбөрүүд ч халамжийн хөтөлбөр дунд явж байгаа нь ядуурал, эмзэг байдлыг бууруулахад нөлөөлөхгүй учраас үр дүнгүй гэж хэлж болно.

Монгол улсад хэрэгжиж байгаа нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хийсэн судлаачийн анхдагч дүн шинжилгээгээр хамгийн үр дүнтэй хөтөлбөрөөс үр дүн багатай руу эрэмбэлвэл:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр
2. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж
3. Хүнс тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
4. Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж
5. Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж
6. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
7. Хүүхдийн мөнгөн тэтгэмж
8. “Эхийн алдар” одонтой эхийн тэтгэмж
9. Насны хишиг
10. Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж байна.
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж хөнгөлөлт
12. Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж
13. Алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлт тус тус эрэмблэгдсэн байна.

Гэхдээ нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг оновчгүй гэж хэлэх боломжгүй ч нэг зорилтот бүлэгт чиглэсэн хэд хэдэн хөтөлбөрийг нэгтгэх, амьжиргаа сайтай бүлэгт очиж буй хөтөлбөрүүдийг багасгах, мөнгөн хөтөлбөрүүдийг үйлчилгээ рүү шилжүүлж бусад хөгжингүй улс орнуудын нэг адил төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар үйлчилгээг хүргэх, хууль тогтоомжуудыг шинэчлэн эмзэг хэсэгт очих тэтгэвэр тэтгэмж, дэмжлэгийн үйлчилгээг амьжиргааг хангахуйц хэмжээнд нэмэгдүүлж хүртээмжтэй хүргэхээс гадна тодорхой хэмжээний хөшүүрэгтэй болгох нь үр дүнтэй.

Мөн бидэнд бэлэн байгаа ООГА-өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг оновчтой, Монгол улсын онцлог, нөхцөл байдалд тохируулан боловсронгуй бүрдүүлж чадвал халамжийн хөтөлбөрүүдийг ядуу бүлэгт тусгайлан чиглүүлэх боломжтой юм. Тухайлбал нийгмийн халамжийн зорилтот бүлгээ сонгож буй одоогийн арга буюу хүн амын бүлгээр категорын аргаар тодорхойлж байгаа хөтөлбөрүүдийг ООГАргачлалаар мэдээллийн бааз бүрдүүлсэн 1,2 дугаар түшний өрхүүд рүү чиглүүлбэл дараах 2 төрлийн үр дүнг авчирч болно. Үүнд:

1. Хөтөлбөр илүү үр дүнтэй, зорилтот бүлэгтээ хүрнэ
2. Нийгмийн халамжийн өртөг зардлыг нэмэгдүүлэхгүй байх үр дүнтэй гэж харж байна.

Харин нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд шинжилгээ хийхдээ зааглан авч үзэхэд халамжийн хөтөлбөр болон хүн амын өсөлтийг дэмжих хөтөлбөр, зарим хүн амын бүлгийн алдар гавьяаг үнэлэх урамшуулах хөтөлбөрүүд

“Халамжийн бодлого”-д хамтдаа байгаа учраас халамж хавтгайрч буй ойлголтыг олон нийтэд болон судлаачдад төрүүлж байна. Өөрөөр хэлбэл дээрх 3 хөтөлбөрийг тусад нь авч үзвэл халамж хавтгайрсан гэх ойлголтыг няцаах үр дүн гарч байгаа юм. Иймд Монгол улс нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг хүн амыг өсгөх бодлого, алдар гавьяаг үнэлэх хөтөлбөрүүдээс тусад нь авч үзэж хууль эрх зүйн баримт бичигт тусгах, бодлогын шинэчлэлт хийх хэрэгцээтэй байна.

НОМ ЗҮЙ

[1] Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын статистик-2019 он

[2] Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн эмхэтгэл, Улаанбаатар хот, 2019 он

[3] <http://dictionary.reference.com/browse/social+welfare>

[4] Маргарет Грош, Карло дел Нинно, Эмил Теслуик, Азедин Кергхи нар, Дэлхийн банк, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, “Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцоо” Улаанбаатар хот, 2011 он

[5] Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт” төсөл, “Монголын ардын ухаан арга, билгийн төв” ТББ, “Нийгмийн халамжийн салбарын ажилтнуудыг чадавхжуулах моуль сургалтын гарын авлага -1”, Улаанбаатар хот, 2019 он

[6] Rafael Lindqvist , Kamal Lamichhane, Disability policies in Japan and Sweden: A comparative perspective, Accepted 21 August 2018

[7] Rafael Lindqvist , Kamal Lamichhane, Disability policies in Japan and Sweden: A comparative perspective, Accepted 21 August 2018

[8] Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт” төсөл, “Монголын ардын ухаан арга, билгийн төв” ТББ, “Нийгмийн халамжийн салбарын ажилтнуудыг чадавхжуулах моуль сургалтын гарын авлага -1”, Улаанбаатар хот, 2019 он

[9] Маргарет Грош, Карло дел Нинно, Эмил Теслуик, Азедин Кергхи нар, Дэлхийн банк, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, “Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцоо” Улаанбаатар хот, 2011 он

[10] Маргарет Грош, Карло дел Нинно, Эмил Теслуик, Азедин Кергхи нар, Дэлхийн банк, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, “Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцоо” Улаанбаатар хот, 2011 он

[11] Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Дэлхийн банк, Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ 2015 он

[12] Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт, “Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох ортопед болон тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ” Улаанбаатар хот, 2019 он

[13] Людовико Карраро, Б.Энхцэцэг, Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн ерөнхий нөхцөл байдал, Улаанбаатар хот, 2016 он

[14] Монгол улсын үндэсний статистикийн хороо, Нийгмийн хамгааллын статистик 2019, Улаанбаатар хот, 2020 он

[15] “Зохистой хөдөлмөрийг дэмжих 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь” ОУХБ, ҮСХ, Улаанбаатар хот, 2019 он